

“ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА”

2018

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ

Судалгааны захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэгч:

“Мирим Консалтант” ХХК

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Очирхуяг	Багийн ахлагч, хуульч
Х.Дондог	Оюуны өмч, инновацийн зөвлөх
Я.Бямбасүрэн	Төрийн удирдлага, бодлогын зөвлөх
Х.Бямбасүрэн	Эдийн засаг, статистикийн зөвлөх
Д.Майдри	Туслах судлаач, хуульч

Судалгааг хянасан:

Н.Янжинпагма	“Мирим Консалтант” ХХК-ийн гүйцэтгэх захирал
--------------	--

Гарчиг

Гүйцэтгэгч:	2
Судалгааг гүйцэтгэсэн:	2
Судалгааг хянасан:	2
УДИРТГАЛ	4
I. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ	4
II. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ	6
1. Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хууль болон уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга	6
2. Төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох	7
III. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ	10
1. Зорилгод хүрэх байдал	10
2. ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ	37
3. ХАРИЛЦАН УЯЛДАА	39
IV. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	40
Эх сурвалж	40

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Патентын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

I. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтүүдээс доох хүснэгтэд дурдсан үндэслэлээр Зорилгод хүрэх байдал, Ойлгомжтой байдал, Зардал, Харилцан уялдаа гэсэн 4 шалгуур үзүүлэлтийг сонгог авлаа.

№	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг сонгох
1	Зорилгод хүрэх байдал	“Зорилгод хүрэх байдал” нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглана. Энэхүү үнэлгээний хүрээнд зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Учир нь Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд дурдсанаар “Монгол Улс патентын бие даасан хуультай ч хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан, хуулийн зүйл, заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, түүнчлэн патент, гэрчилгээ олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улсад тогтсон практикт нийцээгүй байна зэрэг асуудалтай байна” гэжээ. Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэсэн эсэх, сонгож авсан шийдлийн зорилгод хүрэх байдлыг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
2	Практикт хэрэгжих	“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн

	боломж	хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно. Энэхүү үнэлгээний хүрээнд үнэлгээний хүрээнд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь Монгол улс нь оюуны өмчийг хамгаалах чиглэлээр 10 орчим олон улсын гэрээнд нэгдсэн орсон байдаг. Патентын тухай хууль өмнө нь манай улсад 1993 оноос хэрэгжиж эхэлсэн, шинээр хуульчлагдах зохицуулалт, арга хэмжээ нь нэгэнт олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан тул уг үнэлгээг хийх ач холбогдолгүй гэж үзлээ. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 1-р сарын 12-ны өдрийн 11-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгон үндсэн чиглэл”-ийн 141-т “Патентын тухай хуульд Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн боловсронгуй болгох” гэж тусгасан байдаг.
3	Ойлгомжтой байдал	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Энэхүү үнэлгээний хүрээнд ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Учир нь одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хууль 6 бүлэг 30 зүйлтэй хууль бол Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 9 бүлэг 60 зүйлтэй болж өөрчлөгдөн системчлэл дахин хийгдэж буй тул зохицуулалтын уялдаа холбоо болон бусад хууль тогтоомжийн стандартыг хангаж буй эсэхийг шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана. Энэхүү үнэлгээний хүрээнд үнэлгээний хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь уг хуулийн төслийг ХЗДХЯ-ны зүгээс боловсруулж, ажлын хэсэгт уг хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд орж ажилласан, нөгөө

		талаас хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагааг хөгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршиж байгаа бөгөөд иргэдийн эрх чөлөөг хязгаарлажбайгаа эсхүл, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн асуудал байхгүй тул уг үнэлгээг хийх ач холбогдолгүй гэж үзлээ.
5	Зардал	“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална. Хууль тогтоомжийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-т “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан тул Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу зардлыг тооцно.
6	Харилцан уялдаа	“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд чиглэсэн тул Патентын тухай хуулийн төслийг уг шалгуур үзүүлэлтээр зайлшгүй шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

II. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

1. Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хууль болон уг хуулийн

шинэчилсэн найруулгын төслийн агуулга

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл
2	ХОЁРДУГААР БҮЛЭГ. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх	ХОЁРДУГААР БҮЛЭГ. Шинэ бүтээл, ашигтай загварын патентын эрхийн хамгаалалт
3	ГУРАВДУГААР БҮЛЭГ. Патент, ашигтай загварын гэрчилгээ олгох	ГУРАВДУГААР БҮЛЭГ. Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, түүнд шүүлт хийх
4	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн эрх	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалт
5	ТАВДУГААР БҮЛЭГ. Оюуны өмчийн байгууллага	ТАВДУГААР БҮЛЭГ. Патент олгох, патентын хүчинтэй хугацаа, патентын хураамж
6	ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Бусад зүйл	ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Патентын олон улсын мэдүүлэг
7		ДОЛООДУГААР БҮЛЭГ. Патентын эрх, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах
8		НАЙМДУГААР БҮЛЭГ. Оюуны өмчийн байгууллага
9		ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. Бусад зүйл

Одоо хэрэгжиж буй хууль 6 бүлэг 30 зүйлтэй байсан бол уг хууль шинэчилсэн найруулгын хүрээнд 9 бүлэг 60 зүйлтэй болжээ.

2. Төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

№	Үр нөлөөг тооцох агуулга	Төслийн холбогдох зохицуулалт
1	Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын агуулга, шалгуур	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4 дүгээр зүйл. Шинэ бүтээл, ашигтай загварын хамгаалалт 5 дугаар зүйл. Шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, шалгуур 6 дугаар зүйл. Шинэ бүтээлд тооцохгүй шийдэл

		7 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патент олгохгүй шийдэл 8 дугаар зүйл.Ашигтай загварын патентаар хамгаалагдах шийдэл, шалгуур 9 дүгээр зүйл.Ашигтай загварт тооцохгүй шийдэл 10 дугаар зүйл.Ашигтай загварын патент олгохгүй шийдэл 28 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентаар хамгаалагдах шийдэл, патент олгох шалгуур 29 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварт тооцохгүй шийдэл 30 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патент олгохгүй шийдэл
2	Оролцогч нар	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 53 дугаар зүйл.Оюуны өмчийн байгууллагын тогтолцоо 54 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг 55 дүгээр зүйл.Оюуны өмчийн улсын байцаагч 56 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
3	Патент авах эрх үүсэх	11 дүгээр зүйл.Патент авах эрх 12 дугаар зүйл.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар 13 дугаар зүйл.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загвар 14 дүгээр зүйл.Зохион бүтээгчийн нэрийг дурдах 31 дүгээр зүйл.Патентын эрх үүсэх, патент авах эрх, зохион бүтээгчийн нэрийг дурдах 38 дугаар зүйл.Ажлын байранд, Засгийн газрын захиалга, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн бүтээгдэхүүний загвар 39 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент олгох 40 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын хүчинтэй хугацаа 41 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын хураамж
4	Патент авах процесс	15 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг гаргах 16 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг 17 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт

		18 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын томъёолол 19 дүгээр зүйл.Товч тайлбар 20 дугаар зүйл.Зураг, бүдүүвч 21 дүгээр зүйл.Давамгайлах эрх, давамгайлах эрхийг хүлээн зөвшөөрөх 22 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох, мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийх 23 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг салгах, нэгтгэх, шилжүүлэх, өөрчлөлт оруулах, цуцлах 24 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт хайлт хийх, нийтэд мэдээлэх 25 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх 26 дугаар зүйл.Ашигтай загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх 27 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварын хамгаалалт 33 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг 34 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварын давамгайлах огноо 35 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийх, анхдагч огноо тогтоох 37 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлт, нийтэд мэдээлэх
5	Патентын олон улсын мэдүүлэг	42 дугаар зүйл.Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу Монгол Улсыг нэр заан мэдүүлсэн олон улсын мэдүүлэг 43 дугаар зүйл.Гаагийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэн бүтээгдэхүүний загварын олон улсын мэдүүлэг 44 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллага нь хүлээн авагч байгууллага болох эрх 45 дугаар зүйл.Патентын олон улсын мэдүүлгийг үндэсний үе шатанд гаргах
6	Патент дагуу үүсэх эрх	46 дугаар зүйл.Зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрх 47 дугаар зүйл.Патентаар олгогдох эрх 48 дугаар зүйл.Патентын эрхийн зөрчилд тооцохгүй байх онцгой нөхцөлүүд 49 дүгээр зүйл.Патентын эрхийг хүчингүйд тооцох 50 дугаар зүйл.Шүүхээс авах арга хэмжээ 51 дүгээр зүйл.Патентын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах

		52 дугаар зүйл. Лицензийн гэрээ
7	Хамгаалалт	57 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх
8	Оюуны өмчийн байгууллагын санхүүжилт	58 дугаар зүйл. Оюуны өмчийн байгууллагын санхүүжилт

III. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

1. Зорилгод хүрэх байдал

1.1 Хуулийн зорилт

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	1.1.Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1.1.Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагааг хөгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршино.

Шинэчилсэн найруулгын төслийн зорилтыг тодорхойлсон заалт одоо хэрэгжиж буй хуулиас илүү зүйтэй байдлаар Патентын тухай хуулийн зорилгыг тодорхойлсон байна. Патентын хуулийн зорилт нь зохион бүтээгчийн өмчлөх эрх, гуравдагч этгээд түүнийг ашиглахтай холбоотой харилцааг зохистой зохицуулснаар шинийг санаачлах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмэр оруулах байдаг.

1.2 Патент болон ашигтай загварын гэрчилгээ

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	3.1.4."патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь	3.1.1."патент" гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар эзэмшигч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг

тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг; 3.1.5."ашигтай загварын гэрчилгээ" гэж ашигтай загварыг эрх бүхий этгээд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;	хүлээн зөвшөөрч, оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;
--	---

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр ашигтай загварын гэрчилгээг халж, ашигтай загварт патент олгохоор хуульчилсан нь ач холбогдолтой юм. Мөн чанарын хувьд ялгаатай боловч баримт бичиг талаас нь харвал ийнхүү өөр нэршил хэрэглэх ач холбогдол байхгүй болно.

1.3 Шинэ бүтээлийн ойлголт, агуулга

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	3.1.1.“шинэ бүтээл” гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг	3.1.2.“шинэ бүтээл” гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

Шинэ бүтээл болохын тулд дор дурдсан агуулгыг бүгдийг хангах ёстой болдог.

- байгалийн хуулийг ашигласан байх
- техникийн шийдэл байх
- зохион бүтээсэн байх
- ашигтай загвараас өндөр түвшний байх

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон одоо хэрэгжиж байгаа хуулийн “шинэ бүтээл”-ийн тодорхойлолд байгалийн хуулийг ашигласан байх, техникийн шийдэл байх, зохион бүтээсэн байх гэсэн шинж агуулагдаж байгаа боловч ашигтай загвараас хэрхэн ялгах талаар агуулга ороогүй байна. Энэ нь шинэ бүтээл болон ашигтай загварыг хооронд нь ялгахад төвөгтэй байдал үүсгэн, маргаан дагуулах эрсдэлтэй.

2	4.7.Дараахь зүйлийг шинэ бүтээлд тооцохгүй:	6 дугаар зүйл.Шинэ бүтээлд тооцохгүй шийдэл 6.1.Дараахьшийдлийг шинэ бүтээлд
---	---	---

4.7.1.нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга; 4.7.2.компьютерийн программ, алгоритм; 4.7.3.аж ахуйн үйл ажиллагаа, оюуны үйлдэл, тоглоом зэрэгт хамаарах хуваарь, дүрэм, аргачлал;	тооцохгүй: 6.1.1.нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга; 6.1.2.компьютерийн програм, алгоритм дангаараа; 6.1.3.аж ахуйн ба бизнесийн үйл ажиллагаа, боловсрол, сургалтын арга, зөвхөн оюуны үйлдэл хийх тоглоом тоглоход зориулсан бүдүүвч, дүрэм, аргачлал; 6.1.4.барилга, байгууламж, газар, талбайн төлөвлөлт, зохион байгуулалт; 5.бүтээгдэхүүний гаднах хийц, хэлбэрт хамаарах уран сайхны шийдэл. 6.2.Компьютерийн програм, алгоритм нь шинэ бүтээлийн бүрэлдэхүүн хэсэг бол энэ нь патентаар хамгаалагдах эсэхэд нөлөөлөхгүй.
--	---

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон одоо хэрэгжиж байгаа хуульд шинэ бүтээл гэж “үйлдвэрлэх арга ажиллагаа” болон “бүтээгдэхүүн” гэж авч үздэг.

Бусад улсад шинэ бүтээлд:

- Бараа бүтээгдэхүүн
- Үйлдвэрлэх арга ажиллагааг хамруулахаас гадна
- Үйлдвэрлэлтэй хамааралгүй арга ажиллагааг мөн хамааруулдаг.

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх шинэ бүтээлийн объект явцуу байна.

3	4 дүгээр зүйл. Шинэ бүтээлийн патент олгох зүйл, шалгуур 4.1.Шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, үйлдвэрлэх шинэ арга ажиллагаа болон шинэ бүтээгдэхүүн зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно. 4.2.Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнийг “ШИНЭ” гэж үзнэ. 4.3. “ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТҮВШИН АГУУЛСАН” гэдэгт шинэ бүтээл нь ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ	5 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, шалгуур 5.1.Шинэ, шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглахболомжтой бүтээгдэхүүн, эсхүл арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг шинэ бүтээлд тооцож патентаар хамгаална. 5.5.Шинэ бүтээлийн шийдлийг үйлдвэрлэлийн аливаа салбарт үйлдвэрлэж буюу ашиглаж болохуйц, эсхүл үр ашиг өгөхүйц байвал “ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАХ БОЛОМЖТОЙ” ГЭЖ ҮЗНЭ.
---	--	---

ХУВЬД ЯЛГАРАХ ДАВУУ ШИНЖ ЧАНАРТАЙг шинжээч тогтоосон байдлыг ойлгоно. 4.4. Тухайн шинэ бүтээлийг үйлдвэрлэлийн аль нэг салбарт ашиглаж болохуйц байвал “ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАХ БОЛОМЖТОЙ” гэж үзнэ. 4.5.Шинэ бүтээлийн шинэ байдлыг техникийн түвшний хувьд тогтоохын тулд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн шинэ бүтээлийн анхдагч огнооноос ӨМНӨ ГАРГАСАН МЭДҮҮЛЭГ болон эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загварын мэдээллийн баримтыг ашиглана. 4.6.Патентийн шинжээч энэ хуулийн 4.1-д заасан шалгуурыг тогтоохдоо Олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагаас шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч болно.	5.2.Техникийн өмнөх түвшинд үл хамаарах техникийн шийдлийг “ШИНЭ” гэж үзэх бөгөөд дараахь нөхцөлийг техникийн өмнөх түвшинд хамааруулна: 5.2.1.шинэ бүтээлийн мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө бичгээр, амаар, эсхүл бусад хэлбэрээр Монгол Улсад болон гадаадад нийтлэгдсэн, эсхүл уламжлагданНИЙТЭД ИЛЭРХИЙ БОЛСОН шийдэл, эсхүл мэдлэг; 5.2.2.шинэ бүтээлийн мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө, эсхүл давамгайлах огнооноос өмнө бусад этгээдийн Монгол Улсад МЭДҮҮЛСЭН, албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн, патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар. 5.3.Шинэ бүтээлд хамаарах мэдээллийг зохион бүтээгч буюу мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл шууд буюу шууд бусаар уг мэдээллийг олж авсан этгээд НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОСОН хэдий ч тэрхүү өдрөөс хойш 12 сарын дотор уг шинэ бүтээлийн патентын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь “шинэ” гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд үүнийг мэдүүлэг гаргагч нотлох үүрэгтэй. 5.4.Шинэ бүтээлийн шийдлийг патентын мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад ХОЛБОДОХ МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ЗОХИХ МЭДЛЭГИЙН ХҮРЭЭНД ИЛЭРХИЙ ЯЛГАРАХ ДАВУУ ШИНЖ ЧАНАРТАЙ байвал “ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТҮВШИН” агуулсан гэж үзнэ. Техникийн өмнөх түвшинд энэ зүйлийн 5.3-т заасан нь хамаарч байвал үүнийг “ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТҮВШИН”тогтооход харгалзахгүй.
---	--

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон одоо хэрэгжиж байгаа хуульд шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, түүний шалгуурын талаар заалтуудыг оруулж өгсөн.Өөрөөр хэлбэл бүхий л шинэ бүтээл патентаар хамгаалагдах боломжгүй. Шинэ бүтээл байгаад зогсохгүй патент авах боломжтой шинэ бүтээлийн шалгуурыг хангах шаардлагатай болдог. Үүнд:

- Аж үйлдвэрлэлд ашиглах боломжтой байх

Одоо хэрэгжиж байгаа хуульд болон уг хуулийн төсөлд “**үйлдвэрлэл**” гэх үгийг хэргэлсэн байх бөгөөд энэ нь зөвхөн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл гэсэн явцуу утгаар ойлгогдох магадлалтай байх тул “**аж үйлдвэрлэл**” гэсэн үгээр сольж аж үйлдвэрийн бүхий л хэв шинжийг хамруулах шаардлагатай.

- Шинэ байх

Одоо хэрэгжиж байгаа хуульд болон уг хуулийн төсөлд “Шинэ” байх гэдгийг тодорхойлохдоо “**техникийн өмнөх түвшин**” гэсэн үг хэрэглэсэн нь шинэ байх гэдэг шалгуурыг “**ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТҮВШИН АГУУЛСАН**” байх гэх шалгууртай хольж хутгах асуудлыг гаргаж байна. Шинэ байх гэдэг нь нийтэд илэрхий болоогүй байхыг л хэдлэг. Иймд шинэчилсэн найруулгын 5-р зүйлийн 2 дахь хэсгийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзлээ. Харин шинэчилсэн найруулгын §5.2.1 бол одоо хэрэгжиж байгаа хуульд байхгүй бөгөөд байх ёстой, зөв агуулгатай заалт юм. Учир нь шинэ бүтээл ямар тохиолдолд шинэ байдлаа алдахыг тодорхойлох гол заалт юм. Гэхдээ уг заалтад “**уламжлагдан**” гэдэг тодорхойгүй үгийг хэрэглэсэн нь зохимжгүй болжээ. Энэ тодорхойгүй агуулгатай заалтыг тодорхой агуулгатай заалт болгон өөрчлөх шаардлагатай.

Түүнчлэн шинэчилсэн найруулгын төсөлд “Шинэ” байхтай холбоотой ач холбогдолтой заалт орж ирсэн нь 5-р зүйлийн 3 дахь хэсэгт “Шинэ бүтээлд хамаарах мэдээллийг **ЗОХИОН БҮТЭЭГЧ** буюу **МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ ӨӨРӨӨ, ЭСХҮЛ ШУУД БУЮУ ШУУД БУСААР УГ МЭДЭЭЛЛИЙГ ОЛЖ АВСАН ЭТГЭЭД** нийтийн хүртээл болгосон хэдий ч тэрхүү өдрөөс хойш 12 сарын дотор уг шинэ бүтээлийн патентын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь “шинэ” гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд үүнийг мэдүүлэг гаргагч нотлох үүрэгтэй” гэж заасаннь шинэ бүтээл нийтэд илэрхий болсноор шинэ байдлаа алдах тохиолдлын дүрмийн бус тохиолдол бөгөөд уг заалт нь зохион бүтээгч, мэдүүлэг гаргагчийг хамгаалах зорилготой. Одоо хэрэгжиж буй хуульд байхгүй зохицуулалт билээ.

- Дэвшилтэт шинж чанартай байх/Хялбараар бодож олох зүйл биш байх/

Одоо хэрэгжиж байгаа хуулийн 4-р зүйлийн 3 дахь хэсгийн заалт болон уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5-р зүйлийн 4 дэх хэсгийн заалт энэ талаар тусгасан бөгөөд дэвшилтэд шинж чанарын талаар “өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад **ХОЛБОДОХ МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ЗОХИХ МЭДЛЭГИЙН ХҮРЭЭНД ИЛЭРХИЙ ЯЛГАРАХ ДАВУУ ШИНЖ ЧАНАРТАЙ** байвал” гэсэн хуулийг ойлгоход төвөгтэй байна. Энэ агуулгыг хүн ойдлгоход энгийн, хялбар болгох шаардлагатай. Дэвшилтэт шинж чанар буюу өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад ялгарах давуу шинж чанар нь тухайн салбарын мэргэжлийн хүнд илэрхий бус байхыг ойлгоно гэх

байдлаар хуульчлах нь зүйтэй.

- Өмнө нь мэдүүлэг гаргаагүй байх/Түрүүлж мэдүүлэг гаргасан этгээдийг хамгаалах зарчим/

Патентын тухай хуулийн 5-р зүйлийн 5.2.2-т “шинэ бүтээлийн мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө, эсхүл давамгайлах огнооноос өмнө бусад этгээдийн Монгол Улсад мэдүүлсэн, албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн, патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар” гэж заасан.

Системчлэлийн хувьд бие даасан заалт байх шаардлагатай.

Энэ талаар шинэчилсэн найруулгын төслийн 11-р зүйлийн 11.5-т “Ижил шинэ бүтээл, ашигтай загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг анхдагч, эсхүл давамгайлах огноотой патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ” гэж заасан байх тул 5-р зүйлийн 5.2.2 гэх заалт байх шаардлагагүй гэж үзлээ.

4	4.7.4.нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл; 4.7.5.хүн, мал, амьтны эмчилгээ, оношилгооны арга; 4.7.6.бичил биетээс бусад амьтан, ургамал болон тэдгээрийг гаргаж авах биологийн арга.	7 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патент олгохгүй шийдэл 7.1.Дараахь шинэ бүтээлийн шийдэлд патент олгохгүй: 7.1.1.нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл; 7.1.2.бичил биетнээс бусад ургамал, амьтан, тэдгээрийн хэсэг, түүнчлэн ургамал, амьтан, тэдгээрийн хэсгийг бий болгох биологийн үндсэн арга; 7.1.3.ургамлын сорт, амьтны үүлдэр; 7.1.4.хүн, мал, амьтны биед хэрэглэх эмчилгээний арга, мэс заслын арга ба оношилгооны арга; 7.1.5.байгалийн бодис, бүтээгдэхүүн, түүнийг түүх, ялгах, салгах, цэвэршүүлэх арга; 7.1.6.хүн, амьтны клон гаргаж авах арга, эсийн генийн төрөлх байдлыг өөрчлөх арга. 7.2.Энэ зүйлийн 7.1.2-т биологийн бус болон микробиологийнүйл ажиллагаа хамаарахгүй. 7.3.Энэ зүйлийн 7.1.4-т хүн, мал, амьтныбиед хэрэглэх эмчилгээний горим,
---	--	--

	мэс засал, эсхүл оношилгоонд хэрэглэгдэх бүтээгдэхүүн, оношлуур, төхөөрөмж, бодис, нийлэмж болон найрлага хамаарахгүй.
--	--

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл гэх мэт аж үйлдвэрлэлд хэрэглэгдэх боломжтой, шинэ, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ бүтээл мөн боловч хуулиар хамгаалсан үнэт зүйлд харш нөлөөтэй шинэ бүтээлд патент олгохгүй байхаар хуульчилсан нь зөв юмаа.

1.4 Ашигтай загварын ойлголт, агуулга

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	3.1.3.“ашигтай загвар” гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг;	3.1.3.“ашигтай загвар” гэж бүтээц, хийцэд хамаарах техникийн шийдлийг;

Ашигтай загвар болохын тулд дор дурдсан агуулгыг бүгдийг хангах ёстой болдог.

- байгалийн хуулийг ашигласан байх
- техникийн шийдэл байх
- зохион бүтээсэн байх

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон одоо хэрэгжиж байгаа хуульд бүрэн байдлаар тодорхойлтыг өгөөгүй байна. Ашигтай загвар гэж байгалийн хуулийг ашиглан зохион бүтээсэн бараа бүтээгдэхүүний хэлбэр, хийц, бүтцэд хамаарах техникийн шийдэл гэж тодорхойлсон нь зөв юм.

2	6.5.Дараахь зүйлийг ашигтай загварт тооцохгүй: 6.5.1.ашигтай загварыг бүртгэхээс өмнө Монгол Улсад тухайн шийдэл нийтэд илэрхий болсон болон нэвтэрч ашиглагдсан; 6.5.2.урьд нь тус улсад болон гадаад оронд хэвлэн нийтлэгдсэн; 6.5.3.нийгмийн ашиг сонирхол, ёс суртахуунд харш шийдэл.	9 дүгээр зүйл.Ашигтай загварт тооцохгүй шийдэл 9.1.Дараахь шийдлийг ашигтай загварт тооцохгүй: 9.1.1.арга, ажиллагаа; 9.1.2.бодис, найрлага, химийн нэгдэл; 9.1.3.энэ хуулийн 7.1.1-д заасан шийдэл
---	---	---

Одоо хэрэгжиж байгаа хуульд үйлдвэрлэлийн аргыг ашигтай загварт хамааруулахаар хуульчилсан байна. Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн 6-р зүйлийн 5 дэх хэсгийн гарчигтайгаа огт холбоогүй агуулгатай байна. Харин шинэчилсэн найруулгаар зөв болгожээ. Олон улсад тогтсон ойлголтоор арга болон бодис нь ашигтай загварт

хамаардаггүй.

3	6 дугаар зүйл. Ашигтай загварын гэрчилгээ олгох зүйл, шалгуур 6.1.Ашигтай загвар нь шинэ, үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой бол зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд гэрчилгээ олгоно. 6.2.Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон ашигтай загварыг “шинэ” гэж үзнэ. 6.3.Ашигтай загвар нь үйлдвэрлэлийн аливаа салбарт ашиглаж болохуйц байвал “үйлдвэрлэлд ашиглах боломжтой” гэж үзнэ. 6.4.Ашигтай загварын шинж чанарууд нь мэдүүлгийн анхдагч огноо хүртэл нийтэд илэрхий болоогүй бол түүнийг “шинэ” гэж үзнэ.	8 дугаар зүйл.Ашигтай загварын патентаар хамгаалагдах шийдэл, шалгуур 8.1.Багаж, хэрэгсэл, төхөөрөмжийн бүтээц, хийц, тохиргоо, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт хамаарах шинэ, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шийдлийг ашигтай загварт тооцож патентаар хамгаална. 8.3.Ашигтай загварыг үйлдвэрлэлд ашиглах боломжтой байх ба үүнийг энэ хуулийн 5.5-д зааснаар ойлгоно. 8.2.Ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө Монгол Улсад үйлдвэрлэлд ашиглагдан нийтэд илэрхий болоогүй, патентын мэдээллийн санд бүртгэгдээгүй техникийн шийдлийг “шинэ” гэж үзнэ.
Гол анхаарах ёстой зүйл нь ашигтай загвар болон шинэ бүтээлийг хооронд нь хэрхэн ялгаж, зааглах асуудал юм. Мэдүүлэг гаргаж буй этгээдэд хууль уншаад ойлгох боломжтой байдлаар хуульчлах нь зүйтэй. Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсэгт “Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон ашигтай загварыг “шинэ” гэж үзнэ” гэж заасан байсныг шинэчилсэн найруулгаас хассан байна. Энэ зөв үү гэдэг асуудал гарч ирнэ. Ашигтай загвар нь техникийн тухайн үеийн түвшингээс давуутайбайх буюу тухайн салбарын мэргэжлийн хүн тухайн үеийн техникийн түвшинд тулгуурлан хялбар байдлаар олчих зүйл биш байх ёстой. Энэ шалгуурыг тавихгүй бол эргээд эдийн засагт саад учруулах, патентаар олгогдох эрхийг уруулан ашиглах магадлалтай. Өөрөөр хэлбэл ашигтай загвар нь өмнө нь нийтэд илэрхий болоогүй ч энгийн хялбар зүйл байж болохгүй бөгөөд энгийн хялбар зүйлд патент ойлгох Патентын тухай зорилтод нийцэхгүй.		
4	6.6.Энэ хуулийн 4.7 дахь хэсгийн заалт ашигтай загварын гэрчилгээ олгоход нэгэн адил хамаарна.	10 дугаар зүйл. Ашигтай загварын патент олгохгүй шийдэл 10.1.Энэ хуулийн 6.1.2, 6.1.4, 6.1.5-д заасан шийдэлд ашигтай загварын патент олгохгүй. 10.2.Энэ хуулийн 6.2 дахь хэсэг ашигтай загварт нэгэн адил хамаарна.

Эхлээд шинэ бүтээл болох эсэх, түүний дараагаар шинэ бүтээлийн патент олгох эсэх

асуудал яригддагтай адилаар эхлээд ашигтай загвар болох эсэх, хэрвээ ашигтай загвар бол ашигтай загварын патент олгох эсэх тухай яригдах юм. Гэтэл ашигтай загварын патент олгох холбоотой зохицуулалт болох 10-р зүйлд шинэ бүтээл болох эсэхтэй холбоотой 6-р зүйлийг ишилсэн нь зохимжгүй бөгөөд логик, утга агуулгын алдаатай болжээ.

Нөгөө талаас ашигтай загварын объектод арга, аргачлал уулаасаа ордоггүй болохыг 1 дэх хэсэгт дурдсан билээ.

6.1.2.компьютерийн **програм, алгоритм** дангаараа;

6.1.3.аж ахуйн ба бизнесийн үйл ажиллагаа, боловсрол, сургалтын арга, зөвхөн оюуны үйлдэл хийх тоглоом тоглоход зориулсан **бүдүүвч, дүрэм, аргачлал**;

6.1.4.барилга, байгууламж, газар, талбайн **төлөвлөлт, зохион байгуулалт**;

Системчлэлийн хувьд шинэчилсэн найруулгын төслийн 9-р зүйлийн 9.1.3 дахь заалт 10-р зүйл рүү орж ирэх нь зүйтэй.

1.5 Бүтээгдэхүүний загварыг тухай ойлголт, агуулга

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	3.1.2.“бүтээгдэхүүний загвар” гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг;	3.1.4.“бүтээгдэхүүний загвар” гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн өвөрмөц онцлог шинжийг агуулсан уран сайхны шийдлийг ;

Бүтээгдэхүүний загвар гэдэг нь хэлбэр, дүрс, өнгө будаг болон эдгээрийн холимог байдлаар харах мэдэрхүйгээр дамжин гоо сайхны мэдрэмж төрүүлдэг зүйлийг хэлдэг. Шинэчилсэн найруулгын бүтээгдэхүүний загварын тодорхойлолт нь илүү тодорхой, зөв тодорхойлолт болсон гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл дараах шинжийг агуулсан байх ёстой.

- Материаллаг хөдлөх хөрөнгийн загвар байх
- Бараа бүтээгдэхүүний өөрийнх нь хэлбэр байх
- Харах мэдэрхүйгээр хүртэх боломжтой байх
- Харах мэдэрхүйгээр дамжуулан гоо сайхны мэдрэмж төрүүлэхүйц байх

2	5 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патент олгох шалгуур 5.1. Бүтээгдэхүүний загвар нь шинэ, гоёл чимэглэлийн болон өвөрмөц шинжтэй бол зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн	28 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентаар хамгаалагдах шийдэл,патент олгохшалгуур 28.1.Бүтээгдэхүүний загварын шийдэл нь “ шинэ ” болон “ өвөрмөц шинж ”-ийг агуулсан бол патентаар хамгаалагдана.
---	---	---

этгээдэд патент олгоно. 5.2.Бүтээгдэхүүний загварыг хамгаалахад дараахь шинж чанаруудыг харгалзан үзнэ: 5.2.1.бүтээгдэхүүний загварын шинж чанарууд нь мэдүүлгийн анхдагч огноо хүртэл нийтэд илэрхий болоогүй бол түүнийг “шинэ” гэж үзнэ; 5.2.2.бүтээгдэхүүний загварын шинж чанарууд нь оюуны бүтээлч шинжийг агуулж байвал түүнийг “өвөрмөц шинжтэй” гэж үзнэ; 5.2.3.бүтээгдэхүүний загварын шинж чанарт тухайн бүтээгдэхүүний гадаад шинжийн гоо зүйн болон зохицох онцлог шинж чанарыг хамааруулна. 5.3.Тухайн бүтээгдэхүүний загварт хамаарах шийдэл нь бүтээгдэхүүний үндсэн зориулалтад хамаарах бол патент олгохгүй	28.2.Бүтээгдэхүүний загварын шийдэл ньпатентын мэдүүлгийн анхдагч огноо,эсхүл давамгайлах огнооноос өмнө нийтэд илэрхий болоогүй бол “шинэ” гэж үзнэ. 28.3.Бүтээгдэхүүний загварын шийдлийн шинж чанар нь тухайн бүтээгдэхүүний гадаад гоо зүйн шинжийн болон зохицох онцлог шинж чанарболон оюуны бүтээлч шинжийг агуулжбайвал түүнийг “өвөрмөцшинжтэй” гэж үзнэ. 28.4.Бүтээгдэхүүний загварыг, эсхүл түүнд хамаарах мэдээллийг зохион бүтээгч, эсхүл мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл шууд буюу шууд бусаар уг мэдээллийг олж авсан этгээднийтийн хүртээл болгосон хэдий ч тэрхүү өдрөөс хойш 6 сарын дотор уг бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг Оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь “шинэ” гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүйбөгөөд мэдүүлэг гаргагч үүнийг нотлох үүрэгтэй.
--	---

Бүтээгдэхүүний загвар нь аж үйлдвэрийн оюуны өмчийн нэг төрөл тул өмнөх шинэ бүтээл, ашигтай загвар нэгэн адил аж үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой байх, шинэ байх, бүтээсэн байх ёстой болдог.

Шинэчилсэн найруулгын төсөлд аж үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой байх талаар тодорхой зохицуулалт ороогүй байна.

Түүнчлэн ашигтай загвартай адилаар шинэчилсэн найруулгын төсөлд тухайн салбарын мэргэжлийн хүн хялбар байдлаар бүтээх боломжтой бүтээгдэхүүний загвар биш байх урьдчилсан нөхцөлийг заасан эсэх эргэлзээтэй. Шинэчилсэн найруулгын төслийн 28-р зүйлийн 28.3-т заасан өвөрмөц шинжтэй байх буюу оюуны бүтээлч шинжийг агуулжбайх гэдгийг үүнд хамааруулж ойлгох боломжтой хэдий ч энэ зарим талаараа хэт өргөн, зарим талаараа хэт явцуу харагдаж байх тул тодорхой болгох шаардлагатай.

3 5.4.Дараахь шийдлийг бүтээгдэхүүний загварт тооцохгүй: 5.4.1.төрийн сүлд, туг, далбаа, тамга, шагнал, одон тэмдэг болон гадаад орны төрийн далбаа, бэлгэ тэмдэг, олон улсын байгууллагын тэмдэг, бэлгэдэлтэй ижил, төсөөтэй загвар; 5.4.2. нийгмийн ашиг сонирхол, ёс	29 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварт тооцохгүй шийдэл 29.1.Дараахь шийдлийг бүтээгдэхүүний загварт тооцохгүй: 29.1.1.төрийн сүлд, туг, далбаа, тамга, шагнал, одон тэмдэг болон гадаад орны төрийн далбаа, бэлгэ тэмдэг, олон улсын байгууллагын тэмдэг, бэлгэдэлтэй ижил,
---	---

суртахуунд харш бол; 5.4.3.бусад этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулахаар бол.	төсөөтэй загвар; 29.1.2.нийгмийн ашиг сонирхол, зан суртахуунд харш.
---	---

Шинэчилсэн найруулгын 29-р зүйлийн гарчигийг өөрчлөх шаардлагатай. “Бүтэгдэхүүний загварт тооцохгүй шийдэл” гэлгүйгээр “Бүтээгдэхүүний **ззагварын патент олгохгүй шийдэл**” гэж нэрлэх нь зүйтэй байна.

Одоо хэрэгжиж байгаа хуулийн 5-р зүйлийн 5.4.3-т “бусад этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулахаар бол” гэж заасныг хасах шаардлага байгаа эсэх талаарэргэж харах нь зүйтэй.

1.6 Патентын тухай хуулийн харилцаанд оролцогч

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	3.1.6."зохиогч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиосон хувь хүнийг;	3.1.8.“зохион бүтээгч” гэж оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар зохион бүтээсэн хувь хүнийг;
2	3.1.8."мэдүүлэг гаргагч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын эрхийн хамгаалалт хийлгэж, патент буюу гэрчилгээ авахаар мэдүүлж байгаа зохиогч болон түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдийг;	3.1.7."мэдүүлэг гаргагч" гэж патентын мэдүүлгийг гаргаж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

Мэдүүлэг гаргагч нь хувь хүн, хуулийн этгээд байхаар хуульчилжээ. Гэтэл Монгол Улсын Иргэний хуулийн 7-р зүйлд Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийг тодорхойлж өгсөн. Үүнд:

7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГА** байна.

7.2.Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

7.3.ТӨР, ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БОЛОХ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

Иймд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л этгээд мэдүүлэг гаргагч байхаар хуульчилсан нь зүйтэй юм.

3.1.10."патент, гэрчилгээ эзэмшигч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашигтай загварын гэрчилгээ, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийг;	3.1.9."патентэзэмшигч" гэж патент эзэмших онцгой эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан хувь хүн, хуулийн этгээдийг;
--	---

Патентэзэмшигч нь хувь хүн, хуулийн этгээд байхаар хуульчилжээ. Гэтэл Монгол Улсын Иргэний хуулийн 7-р зүйлд Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийг тодорхойлж өгсөн. Үүнд:

7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГА** байна.

7.2.Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

7.3.**ТӨР, ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БОЛОХ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ** нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

Иймд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л этгээд патент эзэмшигч байхаар хуульчилсан нь зүйтэй юм.

3.1.11."шинжээч" гэж байгалийн болон техникийн ухааны дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий ажилтныг;	53.1.Оюуны өмчийн байгууллагын тогтолцоо нь оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "оюуны өмчийн байгууллага" гэх/,оюуны өмчийн хяналтын улсын байцаагч, шинжээчээс бүрдэнэ.
---	---

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6-р хуулийн 6.1.2-т "шинжээч" гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг хэлнэ гэж заасан.

Патентын тухай хуулиар тодорхойлсон шинжээч нь Шүүхийн шинжилгээний хуульд заасан шинжээч гэх ойлголттой давхардаж төөрөгдөл үүсгэхээр байна.

Түүнчлэн патент олгох процесс дахь шинжээчийн эрх зүйн байдал, шалгуур, хэн шинжээчийг уг процессд оролцуулах, шинжээч хэрхэн оролцох нь тодорхойгүй зохицуулалтгүй орхигдсон байна.

Тухайлбал, шинэчилсэн найруулгын төслийн 25-р зүйлийн 25.5-25.7 хүртлэх заалтад гэнэт шинжээч гэсэн ойлголт гарч ирж байгаа ойлгомжгүй байна.

26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 26.1.Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай	54 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг 54.1.Оюуны өмчийн байгууллага дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ: 54.1.1.оюуны өмчийн хууль тогтоомж,
--	---

загварын асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ: 26.1.1.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авч, хянан шийдвэрлэх; 26.1.2.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ олгох; 26.1.3.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, лицензийн гэрээний улсын бүртгэл хөтлөх; 26.1.4.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх; 26.1.5.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухай мэдээллийг хэвлэн нийтлэх; 26.1.6.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа гаргаж өгөх; 26.1.7.патент, ашигтай загварын гэрчилгээний загварыг тогтоох; 26.1.8.хуулийн этгээд, иргэдийг Патентийн тухай хууль зөрчсөн гэж үзвэл холбогдох байгууллагад мэдэгдэх; 26.1.9.хуульд заасан үндэслэл, журмын дагуу патент, гэрчилгээг хүчингүйд тооцох; 26.1.10.патентийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрх хэмжээнийхээ хүрээнд зохион байгуулах; 26.1.11.патентийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх; 26.1.12.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үнэлгээг	Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг эрх хэмжээний хүрээнд зохион байгуулах; 54.1.2.оюуны өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх талаар санал боловсруулах; 54.1.3.шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг патентын улсын бүртгэлд бүртгэх, патент олгох, хүчингүй болгох, патентын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах; 54.1.4.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох; 54.1.5.гадаад улс, олон улсын оюуны өмчийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах; 54.1.6.албан ёсны тогтмол хэвлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах; 54.1.7.эрх шилжүүлэх гэрээ, лицензийн гэрээг бүртгэх, олон нийтэд мэдээлэх; 54.1.8.оюуны өмчтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа гаргаж өгөх, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт бичгийг гаргуулж авах; 54.1.9.хуулиар харьяалуулсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх; 54.1.10.хууль заасан бусад.
---	--

	зохиогчийн хүсэлтээр баталгаажуулах; 26.1.13.оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах; 26.1.14.эрхлэх асуудлаар байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт бичгийг гаргуулж авах; 26.1.15.оюуны өмчийн сургалт, судалгааны ажлыг нэгдсэн удирдамж, арга зүйгээр хангах; 26.1.16.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, тэдгээртэй хамтран ажиллах; 26.1.17.хуулиар харьяалуулсан маргааныг хянан шийдвэрлэх. 26.2. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ. 26.3. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. 26.4.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын ажлыг технологийн бодлогынхоо бүрэлдэхүүн хэсэг болгон явуулна.	
		55 дүгээр зүйл.Оюуны өмчийн улсын байцаагч 55.1.Оюуны өмчийн байгууллагад оюуны өмчийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллах бөгөөд орон нутагт улсын байцаагч ажиллаж болно. 55.2.Оюуны өмчийн байгууллагын дарга нь оюуны өмчийн улсын ерөнхий

	байцаагч байна. 55.3.Оюуны өмчийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг оюуны өмчийн ерөнхий байцаагч олгоно. 55.4.Оюуны өмчийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь оюуны өмчийн хяналт, шалгалтыг гүйцэтгэхдээ оюуны өмчийн хууль тогтоомж, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно. 55.5.Улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь улсын ерөнхий байцаагчид ажлаа хариуцан тайлагнах бөгөөд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх, үүрэгтэй байна: 55.5.1.хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах; 55.5.2.өөрийн хийсэн шалгалт, илрүүлсэн зөрчил, өгсөн албан шаардлага, гаргасан танилцуулга, дүгнэлт, торгох шийтгэлийн үндэслэл, үнэн зөвийг бүрэн хариуцах; 55.5.3.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулахгүй байх. 55.6.Улсын ахлах байцаагч, улсын
--	---

	байцаагч /"цаашид улсын байцаагч" гэх/ нь улсын ерөнхий байцаагчаас баталсан загвар бүхий үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, дүгнэлт, шаардлага, мэдэгдэл хэрэглэнэ. 55.7.Улсын байцаагчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан заасан хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй. 55.8.Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно. 55.9.Улсын байцаагчийн шийдвэрийн талаар ерөнхий байцаагчид гомдол гаргах бөгөөд түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно. 55.10.Оюуны өмчийн улсын байцаагчийн ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
27 дугаар зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч 27.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, 25 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна. 27.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авна. 27.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. 27.4.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны	56 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч 56.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хуульд заасны дагуу оюуны өмчийн байгууллага, шүүх болон эрх бүхий байгууллагад төлөөлүүлэгчийг төлөөлөх эрхтэй байна. 56.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, хуульд заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд байна. 56.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно. 56.4.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны

тэмдгийн эрхийн хамгаалалтын төлөөллийн үйл ажиллагааны тайланг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх бөгөөд үйлчилгээний хөлсний 10 хувийг Оюуны өмчийн газарт өгнө.	өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, 25 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна. 56.5.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах хуулийн этгээд нь 3-аас доошгүй оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байна. 56.6.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйл ажиллагаандаа оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг баримтална.
28 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх 28.1.Эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийг хууль бусаар ашигласнаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, бүтээл ашигласны төлбөр гаргуулахтай холбогдон үүссэнээс бусад маргааныг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх маргаан шийдвэрлэх комисс гомдлыг хүлээн авснаас хойш 6 сарын дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ. 28.2.Маргаан шийдвэрлэх комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй. 28.3.Маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	57 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх 57.1.Патентын эрхийн асуудлаар дараахь гомдлыг Маргаан шийдвэрлэх зөвлөл хянан шийдвэрлэнэ: 57.1.1.Патентын тухай хуульд заасан үйл ажиллагаатай холбоотой мэдүүлэг гаргагчийн гомдол; 57.1.2.хуульд заасан үндэслэлээр патентын мэдүүлэгт гаргасан гуравдагч этгээдийн эсэргүүцэл; 57.1.3.бүртгэгдсэн патентын эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүйд тооцуулах тухай хүсэлт; 57.1.4. хуульд заасан бусад. 57.2.Энэ зүйлийн 57.1.1-д заасан гомдлыг мэдүүлэг гаргагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана. 57.3.Энэ зүйлийн 57.1.2-т заасан эсэргүүцлийг патентын мэдүүлэг анх хэвлэгдсэн өдрөөс хойш 3 сарын дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана. 57.4.Энэ зүйлийн 57.1.3-т заасан хүсэлтийг патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын

	патентын мэдээлэлд хэвлэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана. 57.5.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь энэ зүйлийн 57.1-д заасан гомдол, эсэргүүцэл, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ. 57.6.Холбогдох этгээд Маргаан шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй. 57.7.Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 57.8.Маргаан шийдвэрлэх зөвлөлийг бүх гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. 57.9.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь шинжээч, улсын байцаагчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, эсхүл хэвээр үлдээх шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. 57.10.Маргаан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолыг оюуны өмчийн байгууллагын дарга хянаж, тушаалаар баталгаажуулна. 57.11.Оюуны өмчийн байгууллагын дарга Маргаан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл өөрчлөх, эсхүл хүчингүй болгоно. 57.12.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, түүнчлэн патентын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргах эрхтэй.
--	---

1.7 Патент авах эрх

№	Одоо хэрэгжиж байгаа Патентын тухай хуулийн агуулга	Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга
1	4.1.Шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, үйлдвэрлэх шинэ арга ажиллагаа болон шинэ бүтээгдэхүүн зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно. 16.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч дараахь эрх эдэлнэ: 16.1.1.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвараа өмчлөх; 16.1.2.патент, гэрчилгээ авах эрхээ бусад этгээдэд шилжүүлэх; 16.1.3.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартаа нэр өгөх; 16.1.4.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын технологийн баримт бичиг боловсруулах, тэдгээрийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд оролцож, хяналт тавих, оюуны бүтээлээ үнэлэх; 16.1.5.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглаж олсон бусад этгээдийн орлогоос зохих хэмжээний төлбөр авах. 16.2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар хамтран бүтээсэн зохиогчид патент авах эрхийг хамтран эдэлнэ. 16.3.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг болон техникийн баримт бичиг бүрдүүлэх, санхүүжүүлэх, туршилт хийх зэргээр туслалцаа үзүүлсэн этгээдийг хамтран зохиогч гэж тооцохгүй. 16.4.Хамтран зохиогчид гэрээнд өөрөөр заагаагүй бол мэдүүлэг гаргах, патент,	11 дүгээр зүйл.Патент авах эрх 11.1.ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРзохион бүтээгч нь патент авах, патент авах эрхээ өв залгамжлуулах, бусдад шилжүүлэх эрхтэй. 11.2.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг ажил олгогч эдэлнэ. 11.3.Шинэ бүтээл, ашигтай загварыг гэрээний үндсэн дээр зохион бүтээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол патент авах эрхийг захиалагч, эсхүл санхүүжүүлэгч этгээд эдэлнэ. 11.4.Шинэ бүтээл, ашигтай загварыг хамтран зохион бүтээсэн бол патент авах эрхийг хамтран эдэлнэ. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээхэд техникийн, зохион байгуулалтын, эсхүл санхүүгийн туслалцаа үзүүлсэн, эсхүл патентын мэдүүлэг гаргах, патент авахад дэмжлэг үзүүлсэн этгээдийг хамтран зохион бүтээгч гэж тооцохгүй. 11.5.Ижил шинэ бүтээл, ашигтай загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг анхдагч, эсхүл давамгайлах огноотой патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ.

	гэрчилгээ авах, бүтээлээ ашиглуулах, бусад этгээдэд худалдах, шилжүүлэх, үнэлэх болон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартай холбоотой харилцаанд тэгш эрх эдлэх бөгөөд хэн нэг нь бусад хамтран зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа эрх эдлэхгүй. 16.5.Ижил шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тусдаа бүтээсэн бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад түрүүлж мэдүүлэг өгсөн зохиогч, харин давамгайлах огноо мэдүүлсэн тохиолдолд эхэлж давамгайлах огноотой мэдүүлэг өгсөн зохиогч патент, гэрчилгээ авах эрх эдэлнэ.	
Иргэний хуулийн 8-р зүйлийн 8.1.4-т оюуны үнэт зүйл бүтээснээр иргэний эрх зүйн харилцаа үүсэхээр заасан. Шинэ бүтээл бий болгосноор зохион бүтээгчид патент авах эрх үүсэх бөгөөд уг эрхээ бусдад шилжүүлж болохыг баталгаажуулах нь чухал юм.		
2	16.6.Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бүтээсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварт гэрчилгээ авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ. 16.7.Ажил олгогч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг бүтээснээс хойш 6 сарын дотор мэдүүлэг гаргаагүй бол зохиогч нь мэдүүлэг гаргах эрх эдэлнэ. 16.8.Энэ хуулийн 16.7-д зааснаар зохиогч өөрийн нэр дээр патент, гэрчилгээ авсан тохиолдолд ажил олгогч тухайн бүтээлийг ашиглахдаа патент, гэрчилгээ эзэмшигчид гэрээний үндсэн дээр зохих төлбөр төлнө.	12 дугаар зүйл.Ажлын байрандахь шинэ бүтээл, ашигтай загвар 12.1.Шинэ бүтээл, ашигтай загварыг дараахь тохиолдолд ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар гэж үзнэ: 12.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад зохион бүтээсэн; 12.1.2.ажил олгогчийн өгсөн албан даалгаврыг биелүүлэх явцад зохион бүтээсэн; 12.1.3.ажил олгогчийн технологи, төхөөрөмж, материал, мэдээлэл, туршлага зэрэг нөөцийг ашиглаж зохион бүтээсэн. 12.2.Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн ажилтан энэ тухай ажил олгогчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

	12.3.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг ажил олгогч оюуны өмчийн байгууллагад гаргана. 12.4.Хэрэв ажил олгогч энэ зүйлийн 12.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор патентын мэдүүлэг гаргаагүй бол патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ. 12.5.Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авсан тохиолдолд зохион бүтээгч ажилтантай гэрээ байгуулж зохих төлбөр төлнө. Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээх үүрэг ажилтанд хүлээлгэж, зохих цалин хөлс олгож байсан бол энэхүү төлбөрийг төлөхгүй. 12.6.Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авснаас хойш 6 сарын дотор, эсхүл патент авахаас өмнө шинэ бүтээл, ашигтай загварыг ашиглаж эхэлсэн бол үүнээс хойш 1 жилийн дотор зохион бүтээгч ажилтантай энэ зүйлийн 12.5-д заасан гэрээг байгуулах бөгөөд уг гэрээгээр төлбөр төлөх нөхцөл, хэмжээ, түүнийг олгох журмыг тусгана. Төлбөрийн хэмжээг тогтооход тухайн шинэ бүтээл, ашигтай загварын эдийн засгийн үнэлгээ, ашигласнаас олох үр ашиг, хоёр талын оруулсан хувь нэмэр зэргийг харгалзана. 12.7.Энэ зүйлийн 12.5-д заасан гэрээ байгуулаагүй тохиолдолд төлбөрийн хэмжээг тогтоолгохоор шүүхэд хандаж болно. 12.8.Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ.
Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон одоо хэрэгжиж байгаа хуульд ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрх хэнд байх вэ гэдэг талаар хуульчилсан байна.	

Энэ тогтолцооны гол агуулга ажилтан болон ажил олгогчийн хоорондын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх явдал байдаг. Шинэ бүтээл, ашигтай загвар бүтээх төсөлд ажил олгогч хөрөнгө оруулалт хийх явдлыг дэмжих, нөгөө талаас зохион бүтээгч болох ажилтны шинэ бүтээл бүтээх сэдлийг нэмэгдүүлэх байдаг.

Шинэчилсэн найруулгын төсөлд 11-р зүйлийн 11.2-т “Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг **ажил олгогч эдэлнэ**” гэж заажээ. Одоо хэрэгжиж буй хуулийн 16-р зүйлийн 6 дахь хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бүтээсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварт гэрчилгээ авах эрхийг **гэрээнд өөрөөр заагаагүй бол** ажил олгогч эдэлнэ” гэж заасан байдаг.

Шинэчилсэн найруулгын заалт зохион бүтээгч болох ажилтны ашиг сонирхлыг орхигдуулсан байна. Ажилтан, ажил олгогчийн тохиролцоог харгалзалгүй шууд ажил олгогч патент авах эрхтэй байх нь зохисгүй. Одоо байгаа заалт нь “патент авах эрхийг **гэрээнд өөрөөр заагаагүй бол** ажил олгогч эдэлнэ” гэж заасан ажилтан болон ажил олгогчийн хооронд ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн заалт юм. Уул нь “патент авах эрхийг **гэрээнд өөрөөр заагаагүй бол** АЖИЛТАН эдэлнэ” гэж заах нь хамгийн зөв шийдэл болно.


Түүнчлэн шинэчилсэн найруулгын төслийн 12-р зүйлийн 5 дахь хэсэгт “Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авсан тохиолдолд зохион бүтээгч ажилтантай гэрээ байгуулж зохих төлбөр төлнө. Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээх **үүрэг ажилтанд хүлээлгэж, зохих цалин хөлс олгож байсан** бол энэхүү төлбөрийг төлөхгүй” гэсэн заалт оруулсан нь зохион бүтээгч ажилтны ашиг сонирхлыг орхигдуулжээ. Энэ нь шинэ бүтээл бүтээх ажилтны сэдлийг бууруулах, ажил олгогч уг заалтыг урвуулан ашиглах явдлыг урин дуудсан хэрэг юм.

3	16.9.Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартай холбоотой харилцаанд судлаач, түүний ажилладаг танхим, лаборатори болон их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага тэгш эрх эдэлнэ. 16.10.Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг төрийн өмчит үйлдвэрийн газарт нэвтрүүлснээс олсон роялти орлого нь уг оюуны өмчийн эрхийг эзэмшигч тухайн их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын жилийн төсвийн таван хувиас хэтрэхгүй байна.	13 дугаар зүйл.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загвар 13.1.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн бол энэ тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. 13.2.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгч эдэлнэ. 13.3.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн
---	---	---


	эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон шинэ бүтээл, ашигтай загварт патент авах эрхийг захиалагч эдлэхээр гэрээнд заасан бол патент авах эрхийг эрх шилжүүлэх гэрээний үндсэн дээр захиалагчид шилжүүлнэ. 13.4.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг захиалагч төрийг төлөөлж эдлэхээр гэрээнд заасан бол захиалагч энэ зүйлийн 13.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор оюуны өмчийн байгууллагад патентын мэдүүлэг гаргаж болох бөгөөд патентын мэдүүлэг гаргаагүй тохиолдолд патент авах эрхийг гүйцэтгэгч эдэлнэ.
Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 13-р зүйлийн агуулга одоо хэрэгжиж буй хуулийн зохицуулалтыг тодорхой, ойлгомжтой болгож шинэчлэн найруулсан байна.	
	14 дүгээр зүйл.Зохион бүтээгчийн нэрийг дурдах 14.1.Зохион бүтээгч нэрээ дурдуулахаас татгалзсан тухай Оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, патент, албан ёсны тогтмол хэвлэлд зохион бүтээгчийн нэрийг дурдана
Зохион бүтээгчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах нь аж үйлдвэрийн оюуны өмч бүтээх явдлыг дэмжихэд чухал ач холбогдолтой.	
	31 дүгээр зүйл.Патентын эрх үүсэх, патент авах эрх, зохион бүтээгчийн нэрийг дурдах 31.1.Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн онцгой эрх нь бүтээгдэхүүний загварыг Оюуны өмчийн байгууллагад бүртгүүлснээр үүснэ. 31.2.Патент авах эрхийг бүтээгдэхүүний загвар зохион бүтээгч эдлэх бөгөөд патент авах эрхээ өв залгамжлуулж, эсхүл бусдад шилжүүлж болно.

		31.3.Бүтээгдэхүүний загварыг ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр зохион бүтээсэн бол патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч, эсхүл санхүүжүүлэгч этгээд эдэлнэ. 31.4.Хоёр ба түүнээс дээш этгээд бүтээгдэхүүний загварыг хамтран зохион бүтээсэн бол патент авах эрхийг хамтран эдэлнэ. 31.5.Ижил бүтээгдэхүүний загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг анхдагч, эсхүл давамгайлах огноотой патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ. 31.6.Зохион бүтээгч нэрээ дурдуулахаас татгалзсан тухай Оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг, патент, патентын албан ёсны тогтмол хэвлэлд зохион бүтээгчийн нэрийг заавал дурдана.
Бүтээгдэхүүний загварын хувьд шинэ бүтээл, ашигтай загварын адил патенттай холбоотой эрх үүсдэг. Одоо хэрэгжиж буй хуулиар шинэ бүтээл болон бүтээгдэхүүний загварын харилцаа нь нэг стандартаар зохицуулагдаж буй нь зарим талаараа зөв гэж хэлж болохуйц байна. Шинэчилсэн найруулгын төслийн 31-р зүйлд туссан агуулга шинэ бүтээл болон ашигтай загвартай холбоотой өмнөх зүйл заалтуудтай туссан агуулгатай ижилхэн давтсан шинжтэй байна.		


1.8 ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТ ОЛЖ АВАХ ПРОЦЕСС



1.9 АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ОЛЖ АВАХ ПРОЦЕСС



1.10 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ОЛЖ АВАХ ПРОЦЕСС



2. ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

№	ТӨСЛИЙН ЗААЛТ	ТАЙЛБАР
1	3.1.7."мэдүүлэг гаргагч" гэж патентын мэдүүлгийг гаргаж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг; 22.1.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор патентын мэдүүлэг хүлээн авсан тухай мэдүүлэг гаргагчид, эсхүл оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч (цаашид "мэдүүлэг гаргагч" гэх)-д бичгээр мэдэгдэнэ.	Мэдүүлэг гаргагч гэсэн нэр томьёо давхардсан. Алийг нь мэдүүлэг гаргагч гэж ойлгох тодорхойгүй
2	3.1.11."анхдагч огноо" гэж энэ хуульд заасан шаардлага хангасан патентын мэдүүлгийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагахүлээн авсан, эсхүл Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоо хүлээн авсан он, сар, өдрийг; 22.3.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөр анхдагч огноо тогтоож, мэдүүлгийн улсын бүртгэлд бүртгэсэн тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.	Одоо хэрэгжиж байгаа хуульд анх хүлээн авсан он, сар, өдрийг анхдагч огноо байхаар хуульчилсан, мэдүүлэг гаргагч мэдүүлэг гаргаж байгаа тул анх мэдүүлэг гаргасан өдөр гэх нь ойлгомжтой юм.
3	22.5.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт хийх тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө. 22.6.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.5-д заасан хугацааг гурван сар хүртэл хугацаагаар сунгуулах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.	2 сарын, гурван сар гэж хугацааг илрэхийлэхдээ үсэг, цифр хольж хэрэглсэн байна. Хугацааг нэг бол үсэг, нэг бол цифрээр илэрхийлэх байдал олон заалт дээр гарж байна.
4	22.14.Энэ зүйлийн 22.13-т заасан хугацаанд, эсхүл сунгагдсан хугацааны дотор ирүүлсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй бол Оюуны өмчийн байгууллага нь патентлагдах түвшин тогтоох шаардлага хангуулахаар	Дугаарлалт алдсан байна. Уг нь "энэ зүйлийн 22.12, 22.13-т заасан хугацааны" гэвэл ойлгомжтой байна.

	мэдүүлэг гаргагчид мэдэгдэх ба мэдүүлэг гаргагч нь 20 хоногийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.	
5	22.9.Оюуны өмчийн байгууллага нь ашигтай загварын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос хойш 2 сар, шинэ бүтээлийн мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 12 сарын дотор хийж, энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, техникийн өмнөх түвшинг илрүүлэх боломжтой эсэхийг тогтооно. 24.2.Ашигтай загварын хайлтын тайланг анхдагч огнооноос хойш 2 сар, шинэ бүтээлийн хайлтын тайланг анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авснаас өдрөөс хойш 12 сарын дотор гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.	Тухайлбал ашигтай загварын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос хойш 2 сар, хайлтын тайланг анхдагч огнооноос хойш 2 сар гэж давхардуулж заасан нь ойлгомжгүй байна.
6	5 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, шалгуур 22.14.Энэ зүйлийн22.13-т заасан хугацаанд, эсхүл сунгагдсан хугацааны дотор ирүүлсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй бол Оюуны өмчийн байгууллага нь патентлагдах түвшин тогтоох шаардлага хангуулахаар мэдүүлэг гаргагчид мэдэгдэх ба мэдүүлэг гаргагч нь 20 хоногийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө. 25.3.Дэвшүүлж байгаа шийдэл нь энэ хуулийн 5-7 дугаар зүйлд заасан патентлагдах чадварын шалгуур хангасан эсэх тухай мөн чанарын шүүлтийн дүгнэлт гаргаж, тайлангийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ. 25.4.Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5-7 дугаар зүйлд заасан патентлагдах чадварын шалгуур хангасан бол шинэ бүтээлийн ном зүй,товч тайлбар,тодорхойлолт, томьёоллыг албан ёсны тогтмол хэвлэлд 30 хоногийн дотор нийтэлнэ.	Патентын шалгуур, патентлагдах түвшин, патентлагдах чадварын шалгуур гэсэн 3- өөр нэр томьёог нэг агуулгад хэрэглэсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

3. ХАРИЛЦАН УЯЛДАА

№	Хариулах асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1	Төслийн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
2	“Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хамаарч байна.
3	Нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

IV. ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Ерөнхий дүгнэлт бол одоо хэрэгжиж буй хуультай харьцуулахад агуулгын хувьд маш сайн хуулийн төсөл болжээ.

Гэхдээ анхаарах ёстой гол асуудал:

1. Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүн загвар гэж үзэх шалгуур болон эдгээрт патент олгох шалгуур нь өмнөх хуультай адилаар тодорхойгүй, зарим зайлшгүй байх ёстой орхигдуулсан байна.
2. Мөн чанарын шүүлт хийж буй шинжээчийн чиг үүрэг эрх зүйн байдал тодорхой бус байна.
3. Хувь хүн, хуулийн этгээд зөвхөн уг харилцаанд оролцох боломжтой байдлаар хуульчилсан нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллага аж үйлдвэрийн оюуны өмч олж авах, ашиглах боломжийг хаагдуулж байна.
4. Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг ажил олгогч эдэлнэ гэж заасан нь талуудын хоорондын тохиролцоог үл ойшоосон, ажилтны ашиг сонирхлыг орхигдуулсан заалт болжээ.

I. Зөвлөмж

1. Шинэ бүтээлийн хувьд ашигтай загвараас ялгах шалгуур оруулж өгөх шаардлагатай.
2. Ашигтай загварын хувьд тухайн салбарын мэргэжлийн хүний хувьд хялбар байдлаар бүтээхээргүй бүтээл байх гэсэн шалгуурыг оруулах
3. Бүтээгдэхүүний загварын хувьд мөн тухайн салбарын мэргэжлийн хүний хувьд хялбар байдлаар бүтээхээргүй бүтээл байх гэсэн шалгуурыг оруулах
4. Субъектийн хувьд хувь хүн, хуулийн этгээд гэхээс гадна хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг аж үйлдвэрийн оюуны өмчийн эрхийн субъект байх боломжийг хангах
5. Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийггэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан эдэлнэ гэж оруулах

Эх сурвалж

1. Дэлхийн Оюуны Өмчийн байгууллага байгуулах тухай конвенц
2. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц
3. Патентын хамтын ажиллагааны гэрээ

4. Худалдаан хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр
5. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр
6. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр
7. Патентын олон улсын ангиллын тухай Стасбургийн хэлэлцээр
8. Patent Act(Patentgesetz, PatG)https://www.gesetze-im-internet.de/englisch_patg/englisch_patg.html
9. Patent Law of Russian Federation<https://wipolex.wipo.int/en/text/189120>
10. ATENT ACT<http://www.kipo.go.kr/upload/en/download/PatentAct.pdf>